

ИРГЭНИЙ АЛБАН БУС БОЛОВСРОЛ БОЛОН АМЬДРАЛЫН ОРЧИНД СУРАЛЦАЖ ЭЗЭМШСЭН МЭДЛЭГ, ЧАДВАРЫГ АЛБАН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулахтай холбогдох (цаашид “мэдлэг чадвар”) гэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулийн 3.1.11-д "эзэмшсэн мэдлэг, ур чадвар" гэж иргэн албан бус боловсрол, эсхүл амьдралын орчинд суралцаж эзэмшсэн чадамжийг ойлгоно.

1.3.Иргэний мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагаа нь хүний эрхийг хүндэтгэсэн, тэгш хамруулсан, ашиг сонирхлын зөрчил, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид, мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц дэх мэргэшлийн түвшинд нийцсэн, нээлттэй, ил тод байна.

1.4.Энэхүү журмаар иргэний мэдлэг, чадварыг мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн II-VI түвшинд хүлээн зөвшөөрч, баталгаажуулах харилцааг зохицуулна. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн I болон VII түвшний мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулахгүй.

1.5.Эзэмшсэн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрөх нь иргэнээс ирүүлсэн нотлох баримтыг бүрдүүлэх, түүнд дүгнэлт хийх, дүгнэлтэд үндэслэн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнг тайлагнах үйл ажиллагаанаас бүрдэнэ.

1.6.Иргэний мэдлэг, чадварыг энэхүү журмын 1.4-д заасан үйл ажиллагааны үр дүнд үндэслэн баталгаажуулна.

1.7.Арваас доош насны хүүхдийн албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж, эзэмшсэн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулахгүй.

1.8.Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн III-VI түвшинд 14-өөс доош насны хүүхдийн албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж, эзэмшсэн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулахгүй.

Хоёр.Хүсэлт гаргах

2.1.Иргэн мэдлэг, чадвараа албан боловсролын зохих түвшинд хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулах хүсэлтээ харьяалах аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (цаашид “төв” гэх)-д гаргана.

2.1.1.Алслагдсан сум, багийн иргэн хүсэлтээ тухайн суман дахь албан бус боловсролын багшаар дамжуулан төвд гаргаж болно.

2.2.Иргэн хүсэлтээ гаргахад доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

2.2.1.өргөдөл;

2.2.2.төрсний гэрчилгээ эсхүл иргэний үнэмлэхийн хуулбар (лавлагаа);

2.2.3.иргэн боловсролын сургалтын байгууллагад өмнө нь суралцаж байсан бол нотлох баримт бичиг (эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувь)-ийн хамт;

2.2.4.иргэн амьдралын орчноос сурсан мэдлэг, чадвар эзэмшсэнийг нотлох баримт (бүтээлийн сан, ажлын байрны тодорхойлолт, тухайн улсад ажилласныг тодорхойлох баримт, зураг, дүрс бичлэг, бусад)-ийн хамт.

Гурав.Зохион байгуулалт

3.1.Төв энэхүү журмын 2.2-т заасан иргэний хүсэлтийг Боловсролын ерөнхий хуулийн 43.2-д заасан системд бүртгэнэ.

3.2.Төв нь хүсэлт гаргасан иргэний холбогдох нотлох баримтыг бүрдүүлж, доор дурдсан этгээдэд хүргүүлнэ.

3.2.1.Иргэн албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн ерөнхий боловсролын мэдлэг, чадвараа Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн II-IV түвшинд хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах бол аймаг, нийслэлийн боловсролын газарт;

3.2.2.Иргэн албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэргэшлийн мэдлэг, чадвараа Мэргэшлийн шаталсан бүтцийн IV-VI түвшинд хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах бол тухайн орон нутаг дахь Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагад.

3.3.Иргэн албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн ерөнхий боловсролын мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Боловсролын газрын даргын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна.

3.4.Энэхүү журмын 3.3-т заасан ажлын хэсэг иргэний бүрдүүлсэн нотлох баримтад үндэслэн цаг хугацаанаас үл хамааран үнэлгээ хийж, Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн II-VI түвшинд үнэлж, дүгнэлт гарган, хүсэлт гаргасан иргэнд мэдлэг, чадвараа хөгжүүлэх, суралцах, боловсрол нөхөн эзэмшихтэй холбоотой зөвлөмжийг санал болгож болно.

3.5.Ажлын хэсэг нь энэхүү журмын 3.4-д гаргасан дүгнэлтэд үндэслэн иргэний эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх ба үнэлгээг тухайн түвшний сургалтын хөтөлбөрийн зорилт дахь мэдлэг, чадварт суурилан зохион байгуулна.

3.6.Ажлын хэсэг нь үнэлгээний үнэн зөв, тохирцтой, найдвартай байдлыг хариуцан ажиллах ба үнэлгээтэй холбоотой аливаа өргөдөл гомдолд хариу өгч ажиллана.

3.7.Үнэлгээний үр дүнг 100 хүртэлх оноогоор дүгнэх ба 65-аас доош оноотой үнэлэгдсэн иргэний мэдлэг, чадварыг энэхүү журмын 3.5-д заасан сургалтын хөтөлбөрийн зорилт дахь мэдлэг, чадварын түвшинд хүрээгүй гэж дүгнэнэ. Үнэлгээний үр дүн 65-аас дээш оноотой бол иргэний албан бус боловсрол, амьдралын орчинд эзэмшсэн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрч, аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга албан ёсоор шийдвэр гаргаж, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.8.Хэрэв хүсэлт гаргасан иргэний мэдлэг, чадварын түвшин үнэлгээгээр энэхүү журмын 3.5-д заасан сургалтын хөтөлбөрийн зорилт дахь мэдлэг, чадварын түвшинд хүрээгүй байвал тухайн иргэнд мэдлэг, чадвараа хөгжүүлэх, суралцах, боловсрол нөхөн эзэмшихтэй холбоотой зөвлөмжийг санал болгож, тухайн иргэн болон түүний хүсэлтийг ирүүлсэн төвд албан ёсоор хүргүүлнэ.

3.9.Төв нь иргэн эсхүл түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвлөлдөж суралцах, боловсрол нөхөн эзэмших сургалтын төлөвлөгөөг боловсруулж, холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана.

3.10.Үнэлгээний үр дүнг боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэж, тайлагнах ба доор дурдсан баримт бичгийг хавсаргана. Үүнд:

1.ажлын хэсгийн дүгнэлт

2.үнэлгээний хуудас

3.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын шийдвэр

3.11.Боловсролын ерөнхий газрын дарга аймаг, нийслэлийн боловсролын газрын шийдвэрт үндэслэн иргэнд холбогдох түвшний боловсролын баримт бичгийг олгох шийдвэр гаргаж, олгоно.

3.12.Иргэний мэргэшлийн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг тухайн орон нутаг дахь Мэргэжлийн болон

техникийн боловсрол, сургалтын байгууллага Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.2-д заасан журмын дагуу зохион байгуулна.

3.13.Боловсролын ерөнхий газрын дарга энэхүү журмын 3.12-д заасны дагуу хийгдэх хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны үр дүнд үндэслэн холбогдох түвшний боловсролын баримт бичгийг олгох шийдвэр гаргаж, олгоно.

3.14.Төвүүд албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж, эзэмшсэн мэдлэг, чадвараа хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан эсвэл боловсрол нөхөн эзэмших сургалтад хамрагдаж буй иргэний статистик мэдээллийг жил бүр тайлагнаж ажиллана.

Дөрөв.Санхүүжилт

4.1.Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн ерөнхий боловсролын мэдлэг, чадварыг үнэ төлбөргүй хүлээн зөвшөөрч, баталгаажуулна.

4.2.Иргэний мэргэшлийн мэдлэг, чадвараа хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулахад шаардагдах зардлыг өөрөө хариуцна.

Тав.Бусад

5.1.Иргэний мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах үйл ажиллагаатай холбоотой гарсан аливаа гомдлыг зохион байгуулсан тухайн өдөрт багтаан үнэлгээний багт гаргаж ажлын 5 хоногт шийдвэрлэнэ.

5.2.Боловсролын баримт бичгийг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн, хүчингүй баримт бичгийг баталгаажуулсан тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.